



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

(СОГЭ)	Эдийн Засгийн Ногоон Шилжилт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
БЖДҮ	Бичил Жижиг Дунд Үйлдвэрлэл
ЖДБ	Жижиг Дунд Бизнес
ЖДБЭ	Жижиг Дунд Бизнес Эрхлэгч
МАА	Мал Аж Ахуй
МУИС-ийн БС	Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургууль
НЖДҮҮДТ	Нийслэлийн Жижиг Дунд Үйлдвэр, Үйлчилгээг Дэмжих Төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЭНЭЗ	Нийгэм Эв Нэгдлийн Эдийн Засаг
ОУТББ	Олон Улсын Төрийн Бус Байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТОС	Тогтвортой Санхүүжилтийн Холбоо
УБ	Улаанбаатар Хот
УЗ	Удирдах Зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

АГУУЛГА



4	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
6	УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА
8	БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА
10	ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-Н САЛБАРУУД
12	ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ
16	БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН
18	ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД
32	ДОНОР БАЙГУУЛЛАГЫН АЙЛЧЛАЛ
48	ХАМТРАГЧ ТАЛУУД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, удирдах зөвлөлийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

2022 онд Хөгжлийн Шийдэл төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, хамт байсан та бүхэнд хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлье. Цар тахлын дараа эдийн засгаа сэргээхээр хичээнгүйлэн ажиллаж буй Монгол Улсын нийт аж ахуй нэгжүүдийн нэгэн адилаар Хөгжлийн Шийдэл ТББ нь Улаанбаатар хот болон 12 аймаг дахь 13 салбаруудаараа дамжуулан бизнес эрхлэгчдэд хүрч, өөрсдийн үнэ цэнийг шингээсэн үйлчилгээ үзүүлэхийг хичээн ажиллаж байна.

Өнгөрсөн онд бид нийт 17,479 харилцагч нарт хүрч үйлчлэн, 62.6 тэрбум төгрөгийн зээлийг зуучилж, 1,500 ажлын байрыг шинээр бий болгоход зөвлөгөө өгч ажилласан бөгөөд үүнд манай байгууллагын ажилтан болон харилцагчийн хамтын хүч хөдөлмөр, хүчин чармайлт, түншлэгч байгууллагуудын үр дүнтэй, нягт хамтын ажиллагаа нь чухал хувь нэмэр оруулсныг дурдах нь зүйтэй.

Тайлант хугацаанд Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөр-ийн үйл ажиллагаа нь дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах асуудлыг Монгол Улсад хэрэгжүүлэхэд чиглэгдэж, хөдөө аж ахуйн салбарын ЖДБ-үүдийг илүүтэйгээр дэмжиж ажиллалаа. Энэ үйл ажиллагааны хүрээнд бид шинээр ХАА салбарын туршлагатай хүний нөөцөөр дотоодын багаа зузаатгаж, бизнес хөгжлийн үйлчилгээг хүнс, ХАА-н салбарын үйл ажиллагаатай уялдуулан ажиллаж эхэлсэн онцлогтой жил байлаа.

Оюу Толгой ХХК-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн Бизнесийг Дэмжих” хөтөлбөр дөрөв дэх жилдээ амжилттай хэрэгжиж, Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аж ахуй нэгжүүдийг бизнесээ өргөжүүлэн дэмжих чиглэлээр сургалт, зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлж ажиллаа.



2022 онд бид Европын Холбооны SWITCH Asia хөтөлбөрийн санхүүжилттэй “Эдийн Засгийн Ногоон Шилжилт” (СОГЭ) төслийг Пипл Ин Нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ болон Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой хамтран Улаанбаатар, Эрдэнэт болон Сэлэнгэ аймагт шинээр хэрэгжүүлж эхэлсэн. СОГЭ төсөл нь 2025 он хүртэл хөдөө аж ахуйн хүнс болон шингэн хүнсний салбарын БЖДҮ болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд тохирсон дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлэх, зах зээлд суурилсан ногоон шошгожуулалтын системийг хөгжүүлэн хэрэглэгчдийн хандлагыг өөрчлөх, ногоон санхүүжилтийн хүртээмжээр хангах замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлэн ажиллах юм.

Ирэх 2023 онд манай хамт олныг Хөгжлийн Шийдэл ТББ-ын 15 жилийн ой угтаж байгаа бөгөөд ирэх жил та бүхэнтэй шинэ санаа, шинэ дэвшил, шинэ амжилт ололтуудтай уулзана гэдэгтээ итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ГАНГИС

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Удирдах Зөвлөлийн гишүүд нь орон нутгийн хөгжил, бизнес, эдийн засгийг хөгжүүлэх зорилго чиглэлийг нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дэмждэг хууль эрх зүй, боловсрол, банк санхүү болон уул уурхайн салбарын төлөөллүүд бүхий хараат бус 5 гишүүдээс бүрддэг. Удирдах Зөвлөл нь жилд дөрвөн удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, стратегийн болон цаг үеийн зохих шийдвэрүүдийг гаргах үүрэг бүхий удирдах дээд байгууллага юм.



УЗ Дарга
**Лувсандоржийн
Оюун**
МУИС-ийн БС-ийн Санхүүгийн
Хөтөлбөрийн багш доктор
Профессор



УЗ Гишүүн
Зоригийн Туяа
Нью-Урбанизм ХХК Захирал



УЗ Гишүүн
**Жуковын
Баатарболд**
Тэнгэр Даатгалын Иргэдийн
даатгал хариуцсан захирал



УЗ Гишүүн
**Жамбалдоржийн
Эрдэнэчимэг**
Монголын Эмэгтэйчүүдийн
Холбооны Ерөнхийлөгч асан



УЗ Гишүүн
**Жигжидсүрэнгийн
Гантөмөр**
Хаан Банк Зээлийн бодлого
зохицуулалтын газрын
төслийн зээлийн ахлах
менежер

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2008 оны 8-р сарын 14-ний өдөр үүсгэн байгуулагдсанаасаа хойш хэрэгжүүлж ирсэн 100 орчим төсөл хөтөлбөрөөрөө дамжуулан харилцагч бүрийнхээ өсөлт, дэвшлийн хөшүүрэг нь болж, бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих энтрепренёр сэтгэлгээ, хандлага, бизнесийн ур чадвар, борлуулалтын зах зээл, санхүүжилттэй холбох зэрэг олон талын цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байгаа мэргэшсэн хамт олон юм.

Манай байгууллага нь 2022 оны байдлаар

15 САЛБАРЫН **71** АЖИЛТАНТАЙГААР
ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛЖ БАЙГАА БӨГӨӨД ҮҮНЭЭС

📍 УЛААНБААТАР ХОТОД **34** АЖИЛТАН,
📍 ОРОН НУТГИЙН **14** САЛБАРТ **37** АЖИЛТАН
АЖИЛЛАЖ БАЙНА.



ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ САЛБАНУУД



- Улаанбаатар хот
- Ховд аймаг
- Завхан аймаг
- Баянхонгор аймаг
- Өвөрхангай аймаг
- Өмнөговь аймаг
- Ханбогд сум
- Дорноговь аймаг
- Хэнтий аймаг
- Дорнод аймаг
- Орхон аймаг- SOGE
- Орхон аймаг
- Сэлэнгэ аймаг
- Хөвсгөл аймаг
- Дархан-Уул аймаг

ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ

Алсын хараа

Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийг дэмжих мэргэжлийн цогц үйлчилгээг үзүүлэгч **ШИНЭЛЭГ, ҮР ДҮНТЭЙ, ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА** байна.

Эрхэм зорилго

ӨРХ ГЭРИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛНА



ӨСӨЛТӨД ЧИГЛЭСЭН БИЗНЕСИЙН ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОНО



БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИНЭ



Үнэт зүйлс



Хөгжлийн Шийдэл ТББ нь **АШГИЙН БУС, БИЕ ДААСАН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА** юм.



Хөгжлийн Шийдэл ТББ нь **ХАРИЛЦАГЧ НЭГ БҮРИЙН ХЭРЭГЦЭЭНД ТОХИРСОН ҮНЭ ЦЭНТЭЙ, ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН БИЗНЕС ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ ЦОГЦ ШИЙДЛИЙГ** ӨРГӨН ХҮРЭЭГЭЭР ҮЗҮҮЛДЭГ.



Хөгжлийн Шийдэл ТББ-ын ажилтан бүр **ҮР ДҮНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭДЭГ** БӨГӨӨД ДЭЛХИЙД ТАНИГДСАН БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН АРГА, ТУРШЛАГААР **МОНГОЛ УЛСЫН БИЧИЛ БОЛОН, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮР ЧАДВАРТАЙ.**



**ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА**




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

-  БИЗНЕС ХӨГЖЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
-  МЕНЕЖМЕНТИЙН БОЛОН ЗАСАГЛАЛЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
-  БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
-  БОРЛУУЛАЛТЫН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
-  БИЗНЕСИЙН БҮЛЭГ, ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ
-  ЗЭЭЛ САНХҮҮЖИЛТЭД ХОЛБОХ ҮЙЛЧИЛГЭЭ
-  ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ
-  БИЗНЕС, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА
-  ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
-  МЕНТОРИНГ, КӨҮЧ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

		2022 он	2008-2022 үйл ажиллагааны нийт үр дүн
1	Шинэ бизнес	476	4,948
2	Өргөжин сайжирсан бизнес	1,886	11,272
3	Шинээр бий болсон ажлын байр	1,504	22,392
4	Сургалтад суусан хүмүүсийн тоо	12,122	44,445
5	Ментор	563	1,328
6	Борлуулалтын орлогын өсөлт	14.6 тэрбум ₮	28.5 тэрбум ₮
7	Амжилттай зээлийн зуучлал	62,4 тэрбум ₮	243,2 тэрбум ₮
8	Амжилттай зуучилсан банкны зээлийн тоо	660	10,851
9	Бизнесийн бүлэг хоршоо, төрийн бус байгууллага	33	756
10	16-35 насны бизнес эрхлэгчид	5,546	20,971

Хөгжлийн Шийдэл ТББ-н
харилцагчид



ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТ ӨЛБӨРҮҮД



“ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ” BEST ХӨТӨЛБӨР | 2019-2024



Ц.Отгончимэг
Хашаатын говийн заг ХХК



Ц.Гэрэлтуяа
“Hanna Anna bakery”



Х. Энхбат
Дорнын алтан гутал ХХК

BEST хөтөлбөрийн ЗОРИЛТУУД:

1
ЖДБ-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх

2
ЖДБ-ийн засаглалыг сайжруулах

3
ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон төрийн бус байгууллагуудын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх

4
Бизнесийн хөгжлийн стратегийг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийх

5
Бичил санхүүжилтийн тэтгэлэгт хөтөлбөр

Хөгжлийн Шийдэл ТББ нь USAID-ийн санхүүжилттэй BEST хөтөлбөрийг 4 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлж байгаа ба ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөх зорилготой. BEST хөтөлбөр нь **Улаанбаатар хот, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Ховд, Хэнтий аймгууд** гэсэн нийт 13 салбарт үйл ажиллагаа явуулж байна.

2022 оны 10-р сараас эхлэн BEST хөтөлбөр нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын бизнесүүдийг чадавхжуулах чиглэлээр үйл ажиллагаагаа төрөлжүүлэн ажиллаж эхэлсэн.

BEST хөтөлбөрийн үйл ажиллагаа:

Зорилт 1



- Зээлийн зуучлал
- Бизнес төсөл, санхүү бүртгэлийн чиглэлээр чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээ

Зорилт 2



- Богино болон урт хугацааны зөвлөх үйлчилгээ, сургалт

Зорилт 3



- Бодлого боловсруулагчдад хандсан форум, хэлэлцүүлэг
- Төрийн албан хаагчдыг авилгаас ангид байх, ил тод байдлыг хангах чиглэлээр нөлөөллийн сургалт
- ТББ-н менежментийг сайжруулах сургалт, уулзалт хэлэлцүүлэг

Зорилт 4



- Судалгаа

Зорилт 5



- ЖДБ, гарааны бизнес, ТББ-ийг чадавхжуулах хурдасгуур хөтөлбөр
- Бичил тэтгэлгийн санхүүжилт

ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Зорилт 1

Зээл санхүүжилт авах чадамжийг нэмэгдүүлэх **532** удаагийн чадавхжуулах сургалтад **9,021** хүн, **308** удаагийн мэдлэг, туршлага хуваалцах уулзалт, хэлэлцүүлэгт **7,413** хүн хамрагдсан.

Зээл санхүүжилт авах чадамжийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө болон зээлийн зуучлалын үйлчилгээний үр дүнд **62.6** тэрбум төгрөгийн зээлийг банк санхүүгийн байгууллагаас авахад нь тусалсан.

Зорилт 2

Урт хугацааны засаглалын зөвлөх үйлчилгээнд **62** аж ахуй нэгж, богино хугацааны засаглалын зөвлөх үйлчилгээнд **313** аж ахуй нэгж хамрагдаж нийт **375** харилцагч засаглалаа сайжруулсан.

Зорилт 3

ЖДБ-ийн үйл ажиллагааг дэмждэг төрийн болон ТББ-ын ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх сургалт, уулзалт, нөлөөллийн ажлын үр дүнд **5** удаагийн санал, санаачилгыг гаргасан.

Зорилт 4

ЖДБ-д тулгарч байгаа асуудлыг илрүүлэх зорилгоор "ЖДБЭ дижитал шилжилтийг үнэлэх судалгаа", "Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч буй сорилтууд - Хүйсийн эрх тэгш байдал ба эмэгтэй бизнес эрхлэгчид" гэсэн 2 төрлийн судалгаа хийсэн.

Зорилт 5

Орон нутагт бичил тэтгэлэг олгох зорилтын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон шинэлэг санаа бүхий **27** гарааны бизнес, **16** ЖДБ-т **430** сая төгрөгийн санхүүжилтийн тэтгэлэг олгосон.

2022 болон нийт хөтөлбөрийн гол үзүүлэлтүүд



ӨРГӨЖИН САЙЖИРСАН БИЗНЕС:
1,812 **2,688**



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ӨСӨЛТ:
12,5 тэрбум₮ **19,2** тэрбум₮



НЭМЭГДСЭН АЖЛЫН БАЙР:
1,500 **2,377**

2022 оны үр дүн

Нийт үр дүн



BEST АМЖИЛТЫН ТҮҮХ

"ГОВИЙН ХИЙЦТЭЙ ЦАЙ" ГАРААНЫ БИЗНЕСИЙГ БИЙ БОЛГОХОД БУЦАЛТГҮЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

Өмнөговь аймгийн иргэн **Э.Цогбаяр** нь 2022 оны 4-р сард BEST хөтөлбөрийн бичил санхүүжилтийн тэтгэлэгт хамрагдаж, "Говийн хийцтэй цай" брэндээ бий болгон бизнесээ амжилттай эхлүүлсэн. "Говийн хийцтэй цай" брэнд нь цайны олон төрлийн бүтээгдэхүүнийг агуулсан баялаг орцтой бөгөөд говийн уламжлалт УНД хэмээх цайны амтыг бий болгож чадсан. Одоогийн байдлаар **2 шинэ ажлын байр** бий болгож, сард **13,000** ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн орон нутгийн дэлгүүрүүд болон **Улаанбаатар хотод Номин, GS25 зэрэг томоохон сүлжээ дэлгүүрүүдэд нийлүүлж, бизнесээ амжилттай өргөжүүлж байна.**

НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВТЭЙ ХАМТАРСАН ЗЭЭЛИЙН ӨМНӨХ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



НИЙСЛЭЛИЙН ЖДҮҮДТ

BEST хөтөлбөр нь Нийслэлийн Жижиг, Дунд үйлдвэр, Үйлчилгээг Дэмжих Төв (НЖДҮҮДТ)-тэй байгуулсан санамж бичгийн хүрээнд цар тахлын нөлөөнд шууд болон шууд бусаар өртсөн УБ хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, чадавхжуулах зорилгоор "Цар тахлын үеийн Улаанбаатар хотын жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх богино хугацааны төлөвлөгөө" боловсруулж хэрэгжүүлэв. Энэхүү арга хэмжээнд 5 ангийн **136 бизнес эрхлэгчид** хамрагдаж, зээл, санхүүжилтийн харилцаа болон бизнес төсөл боловсруулах **мэдлэг ур чадвараа дээшлүүлснээр бизнес төслөө боловсруулж, хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилт авахаар арилжааны банкуудад зээлийн хүсэлтээ өгсөн.**



"Тамган Эрдэнэ Хайрхан" ХХК-н захирал **А.Эрдэнэжаргал:**

BEST хөтөлбөрөөс зохион байгуулсан Бизнес хөгжүүлэх Хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж, төсөл бичих аргазүй, зээл, хөрөнгө оруулалтын талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн ба оёдлын бизнесээ өргөжүүлэх төсөл боловсруулж, 3% хүүтэй, 36 сарын хугацаатай, 100 сая төгрөгийн зээл авч чадсандаа туйлын баяртай



136 бизнес эрхлэгч



ИНВЕСКОР ББСБ-ТАЙ ХАМТАРСАН ЗЭЭЛИЙН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



BEST хөтөлбөр нь Инвескор ББСБ болон РиоТинто Монгол ХХК-тай хамтарсан Бизнес хөгжүүлэх Хурдасгуур хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ба үүний үр дүнд ЖДБ эрхлэгчид жилийн **4,8% хүүтэй, 24 сарын хугацаатай зээлийн санхүүжилт** авах боломжтой болсон.

Уг үйл үйл ажиллагаа нь **Зээл санхүүжилтийн өмнөх бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр, Төслийн танилцуулгыг хийх PITCN DAY** арга хэмжээ, **Зээлийн дараах хөгжүүлэх хөтөлбөр** гэсэн 3 үе шаттайгаар 2 сарын хугацаанд хэрэгжиж, **100 гаруй харилцагчийг** бизнес менежментийн ур чадвараа ахиулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд нь дэмжин ажилласан бөгөөд **60 харилцагч 1,531,000,000** төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг авчээ.

Түүнчлэн бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрийг амжилттай төгссөн бизнес эрхлэгчид BEST хөтөлбөрийн дэргэдэх сайн дурын **Захирлуудын клубт** гишүүнээр элсэж, бизнес санаа, туршлагаа хуваалцах, зах зээлээ тэлэхэд хамтын түншлэл бий болгон ажиллаж байна.



“ВиВаЧе Мюзик” ХХК-н захирал
Г.Насанжаргал:

Манай ВиВаЧе хөгжмийн сургалтын төв нь хүүхэд залууст хийл, төгөлдөр хуур, гитар, морин хуур, укулуле хөгжим тоглож сурахад нь туслах, хөгжмөөр дамжуулан урлагийн боловсрол, мэдрэмжийг нь хөгжүүлэх зорилго, үйл ажиллагаатай.

Бизнес санаагаа дөнгөж ажил хэрэг болгож эхэлсэн үедээ BEST хөтөлбөрт хамрагдаж, 1 жилийн дотор Виваче Мюзик ХХК-г үүсгэн байгуулж, хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилт авч чадсан. BEST хөтөлбөрөөс бидэнд өгдөг бизнес хөгжүүлэх сургалтууд, бидний эргэлзсэн асуудлуудын учгийг тайлахад чиглүүлж өгдөг **ганцаарчилсан зөвлөгөөнүүд нь бизнесээ удирдахад** маш их тустай байдаг.

Бид авсан санхүүжилтээрээ хөгжмийн зэмсгийн нэр төрлөө 7 дахин нэмэгдүүлж, мэргэжлийн багш нарын баг бүрдүүлэн бизнесээ амжилттай өргөжүүлж чадсандаа баяртай байна.



60 бизнес эрхлэгч
1,531,000,000₮-ийн зээлийн санхүүжилтийг авсан.

“ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ЖДҮ ХӨГЖИЛД” ФОРУМ

BEST хөтөлбөр нь 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Эдийн засгийн сэргэлтийн бодлого: ЖДҮ Хөгжилд” сэдэвт форумыг зохион байгуулав. Энэхүү форумын зорилго нь Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн сэргэлтийн бодлого, арга хэмжээнүүдийн жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт үүсгэсэн бодит үр нөлөө болон цаашид бий болох боломжуудыг хэлэлцүүлэх, форумын үйл ажиллагаанаас бий

болсон санал, зөвлөмжүүдийг бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарт хүргэх байлаа. Тус форумын үйл ажиллагаанд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Монгол дахь Дэд Дарга Стив Винкэйтс, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Жижиг Дунд Үйлдвэрийн Газрын Дарга Я.Эрдэнэсайхан нар болон ЖДБ эрхлэгчид, ЖДБ-ийн хөгжлийг дэмжин ажилладаг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн **150 хүн** оролцов.

“Эдийн засгийн сэргэлтийн бодлого: ЖДҮ хөгжилд” форумын үеэр Эдийн засгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ ЖДҮ салбарын макро ба микро орчны нөхцөл байдал, эко системийг сайжруулахад анхаарлаа төвлөрүүлэх, ЖДҮ эрхлэгч нарт бий болох бодит үр нөлөө, хүлээлтийг илүү тодорхой болгох шаардлагатай байгааг оролцогчид онцолсон юм.



150 оролцогч

Форумын ИЛТГЭГЧИД



Модератор:

Д.ЖАРГАЛСАЙХАН

Эдийн засгийн ухааны доктор



Сэдэв:

ЖДҮ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЭКО СИСТЕМИЙГ БҮРДҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

Илтгэгч:

П.АМАРМЭНД, Засаглалын зохицуулагч, BEST хөтөлбөр

Сэдэв:

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ЖДҮ САЛБАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ

Илтгэгч:

Б.ТҮВШИНТӨГС, Гүйцэтгэх захирал, Эдийн засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний хүрээлэн

Сэдэв:

ЖДҮ САЛБАРЫН ӨНГӨРСӨН БА ИРЭЭДҮЙ

Илтгэгч:

Н.ЭНХТӨР, Зээл Төслийн Хэлтсийн Дарга, Жижиг Дунд Үйлдвэрийн газар

Сэдэв:

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ЖДҮ САЛБАРЫН БОЛОМЖУУД

Илтгэгч:

С.ДӨЛГӨӨН, Гүйцэтгэх захирал, Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв

Сэдэв:

ЖДҮ САЛБАРЫН ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Илтгэгч:


НАКАМУРА КЕИГО, Япон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын хувийн хэвшлийн хөгжил хариуцсан төлөөлөгч

Сэдэв:

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРЧИМЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР: ХЭРЭГЖИЛТ БА ҮР НӨЛӨӨ

Илтгэгч:

Д.ДУЛАМЗАЯА, Судалгааны Хэлтсийн Дарга, Судалгаа, Статистикийн Газар, Монгол Банк

ЭНТРЕПРЕНЁР ЭМЭГТЭЙЧҮҮД II
ЦАХИМ ФОРУМ




BEST ХӨТӨЛБӨР нь ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ОНЦГОЙ АНХААРАЛ ХАНДУУЛДАГ БӨГӨӨД ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН САНААЧИЛГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГООР ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЭНТРЕПРЕНЁР ЭМЭГТЭЙЧҮҮД ФОРУМЫГ ЖИЛ БҮР ЗОХИОН БАЙГУУЛДАГ.

2022 оны 3 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулсан “ЭНТРЕПРЕНЁР ЭМЭГТЭЙЧҮҮД II” цахим форумд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 175 эмэгтэй бизнес эрхлэгчид оролцож, тэдний өмнө тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг даван туулах арга зам, жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн боломжуудын талаарх илтгэл, олон улсын болон дотоодын сайн туршлагуудтай танилцлаа.

Цахим форумд урилгаар USAID-ын Филиппин, Номхон далай ба Монгол Улсыг Хариуцсан бүсийн Хөгжлийн Хөтөлбөрийн Ерөнхий Зохицуулагч **Режина Маккензи** оролцсон бөгөөд тэрээр “

Ковид цар тахал нь зөвхөн хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй улс орнуудын эдийн засагт, ялангуяа ЖДБ-үүдэд сөргөөр нөлөөлж байна. Хөгжлийн хөтөлбөрүүдийн судалгаанд Эмэгтэйчүүдийн авьяас чадвар, дуу хоолойг сонсохгүйгээр хөгжилд хүрэх ганц ч улс орон байдаггүй. Монгол Улсын хувьд ЖДБ нарын дийлэнх нь эмэгтэйчүүд бөгөөд, тэд улс орныхоо эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байгаад талархалтай байгаагаа илэрхийлсэн.

Мөн энэхүү форумд оролцож байгаа та бүхэн тулгамдаж байгаа бэрхшээл, сорилтуудын талаар нээлттэй илэрхийлж хамтын зөв шийдлүүдийг тодорхойлон бүтээлчээр оролцоно гэдэгт итгэлтэй байна” гэж нээлтийн үгэндээ онцлов.

Форумын
ИЛТГЭГЧИД

Модератор:

Б.БОЛОРЧИМЭГ,

Захирал, Агност Медиа ХХК



Илтгэл:

Илтгэгч:

‘ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГАА’**Ц.Баярхүү,** Тэргүүн дэд захирал, Монголын Эдийн Засгийн Шинжилгээ Судалгааны Төв ТББ

Илтгэл:

Илтгэгч:

**‘ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД
ЗОРИУЛСАН ТӨСЛИЙН ЗЭЭЛ’****Ж.Сосор,** Бүтээгдэхүүн удирдлагын менежер, Хас банк

Илтгэл:

Илтгэгч:

‘ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ САНХҮҮЖИЛТИЙН БОЛОМЖ’**Э.Нандин-Эрдэнэ,** Бодлого, хамтын ажиллагааны ахлах менежер, ТОС холбоо, Уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний санхүүгийн баталгаажсан эксперт

Илтгэл:

Илтгэгч:

**‘БИЗНЕСИЙН САЛБАРТ ТҮҮЧЭЭЛЭГЧ
ЭМЭГТЭЙН ТУРШЛАГА’****Б.Чанцалдулам,** Гүйцэтгэх захирал, Одъ Тан ХХК

Илгэл:

Илтгэгч:

ЭНТРЕПРЕНЕРШИП ДЭХ ДИЖИТАЛЧЛАЛ/ АРМЕН**Лиана Саргсян,** Эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийн зохицуулагч Жинишианы нэрэмжит сангийн дэд захирал, Армян

Илгэл:

Илтгэгч:

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА/ ЭНЭТХЭГ**Аруна Хелен Винодхумар,** Үйл ажиллагаа хариуцсан захирал, BYST

ДЭЛХИЙН БИЧИЛ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ӨДӨР | 2022

Дэлхийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн оруулсан хувь нэмрийг олон нийтэд сурталчлах, тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий ассамблейгаас жил бүрийн 06 дугаар сарын 27-ны өдрийг **“ДЭЛХИЙН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ӨДӨР”** болгон тэмдэглэн өнгөрүүлдэг.

BEST хөтөлбөр нь МУ-ын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг Дунд Үйлдвэрийн Газартай хамтран “Дэлхийн жижиг, дунд үйлдвэрийн өдөр-2022” арга хэмжээг 6 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт Улаанбаатар хотын BEST хөтөлбөрийн 32 харилцагч оролцож өөрсдийн үйл ажиллагааг танилцуулав.

32

ЖДБ

BIZGUIDE

Хөгжлийн Шийдэл ТББ нь онлайн сургалтын систем болох www.learning.bizguide.mn платформыг BEST хөтөлбөрийн харилцагч нарт онлайн орчинд суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор системийг ашиглалтад оруулсан. 2022 оны байдлаар **13 сургалт 42 дэд сэдвийн хүрээнд** онлайн хичээл сургалтын системээр дамжуулан хүргэгдэж байна. Дээрх сургалтуудыг сонголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар байршуулсан.



2022 оны үр дүн:

Шинээр нэмэгдсэн сургалт: **3**

Сургалтад хамрагдсан харилцагчийн тоо: **387**

Нийт хичээл үзсэн цаг: **2148**



ДОНОР БАЙГУУЛЛАГЫН ЗОЧИД ТӨЛӨӨЛӨГЧИД BEST ХӨТӨЛБӨРИЙН ХАРИЛЦАГЧДЫН БИЗНЕСЭЭР АЙЛЧЛАЛ ХИЙВ

2022 ОНД ДОНОР БАЙГУУЛЛАГААС BEST ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, ХАРИЛЦАГЧ ЖДБ-ҮҮДЭЭР ЗОЧИЛСОН ЖИЛ БАЙЛАА.

2022.5.4

Стейси Уоррен, USAID-ын Номхон далай ба Монгол Улсыг хариуцсан бүсийн Хүн ам ба шилжилт хөдөлгөөн Хариуцсан Дэд Захирал



Хатагтай **Стейси Уоррен** нь Монгол улсад ажиллах үеэрээ BEST хөтөлбөрийн харилцагч оёдол, сүлжмэлийн салбарын ЖДБ-үүд болох **Дель Кашмер**, **Хос Учиг**, **Ивээл**, **Хөх урлан** зэрэг компаниудын үйл ажиллагаатай танилцаж, хөтөлбөрийн үр дүнгийн талаар мэдээлэл авсан.



2022.5.11

Райан Уашберн, USAID-ын Филиппин, Номхон Далай ба Монгол Улсыг Хариуцсан бүсийн захирал



Режина Маккензи, USAID-ын Филиппин, Номхон далай ба Монгол Улсыг Хариуцсан бүсийн Хөгжлийн Хөтөлбөрийн Ерөнхий Зохицуулагч



Ноён **Райан Уашберн** болон Хатагтай **Режина Маккензи** нар нь USAID-н санхүүжилт бүхий BEST хөтөлбөрийн тусламжтайгаар борлуулалтын орлогоо нэмэгдүүлж, шинэ ажлын байрыг бий болгосон хоол үйлдвэрлэл эрхлэгч **Роял Грилл Хаус** болон зөөлөн оёдлын үйлдвэрлэл эрхлэгч **Мастер Тэйлоринг** компаниудын ажлын байраар зочиллоо.



2022.8.26

Бетти Чанг, USAID-ын Номхон далайн ба Монгол Улсыг хариуцсан бүсийн Дэд Захирал



Брандон Миллер, USAID-ын Филиппин, Номхон далай ба Монгол улсыг хариуцсан бүсийн Хуулийн мэргэжилтэн.

Этан Такахаши, USAID-ын Филиппин, Номхон далайн ба Монгол Улсыг хариуцсан бүсийн Гэрээний ажилтан



Хатагтай **Бетти Чанг** болон түүний баг BEST хөтөлбөрт хамрагдаж буй Монголын жижиг бизнесийн төлөөлөл болох хүлэмжийн аж ахуй эрхлэгч **Эко Амт ХХК**-д зочлов. Эко Амт ХХК нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Төв аймаг дахь хүлэмжийн үйл ажиллагаанд эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах, материал авахад шаардлагатай санхүүжилтийн зээлээ авч чадсан. Энэхүү чухал санхүүжилтийн үр дүнд ургацынхаа хэмжээг гурав дахин нэмэгдүүлж, жилийн орлогоо дөрөв дахин өсгөсөн байна.



2022.9.27

Аннастасия Хөрт, USAID-ын Филиппин, Номхон далай ба Монгол Улсыг хариуцсан бүсийн Хөтөлбөрийн ажилтан



Хатагтай **Аннастасия Хөрт** нь нь Монгол улсад айлчлах үеэрээ BEST хөтөлбөрийн багт хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, харилцаа тогтооход анхаарах зүйлсийн талаар богино хугацааны сургалт өгсөн. Мөн BEST хөтөлбөрийн харилцагчид болох малгай үйлдвэрлэлийн **Моод коллекшн** болон тавилгын үйлдвэрлэлийн **Булган мебель** компаниудын ажлын байраар зочилж, BEST хөтөлбөртэй хэрхэн холбогдож, ямар үр дүнд хүрээд байгаа талаар мэдээллийг авсан.



“МАЛЧДЫН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР

| 2018-2023

ЗОРИЛГО:

Оюу Толгой ХХК-ны Орон Нутгийн Харилцааны хэлтэстэй хамтран уурхайн нөлөөлд өртсөн малчдын амьжиргааг дэмжих бизнесийн санаачилгуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Үндсэн үйл ажиллагаа:

1. Малчдын бизнес санааг хөгжүүлэх,
2. Малчдын бизнес санааны хэрэгжих боломжийн судалгааг хийх,
3. Малчдын бизнес санааг хэрэгжүүлэх бизнес загварыг тодорхойлох,
4. Малчдын бизнес санааг хэрэгжүүлэх төслийг боловсруулах,
5. Бизнес төслийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийн засаглалын загварыг тодорхойлох,
6. Аж ахуй нэгжийн засаглалын бүтэц, шаардлагатай бүтцийн өөрчлөлт, дүрэм журмын өөрчлөлтүүдийг хийхэд зөвлөгөө өгөх,
7. Бизнес төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой менежментийн зөвлөх үйлчилгээ,
8. Бизнесийн стратеги төлөвлөгөөг боловсруулах,
9. Бизнес төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх

Үр дүн:

2022 онд ЖДБ-ийг хөгжүүлэх чиглэлээр **65** малчныг хамруулсан сургалт, зөвлөх үйлчил дараах үр дүнгүүд гараад байна.

1. Гавилууд Шилмэл Сүрэг хоршоо нь Гавилууд омгийн хонины цөм сүрэг бүрдүүлэх төслийг хэрэгжүүлж байна.
2. Үнээгийн Говь хоршоо нь говийн нөхцөлд Ангус үүлдрийн үхэр үржүүлэх төслийг хэрэгжүүлж байна.
3. Говь Хан Уран ХХК нь оёдлын үйлдвэр байгуулан Оюу Толгой ХХК-д ажлын хувцасны нийлүүлэлт хийж байна.
4. Энергийн-Ундарга хоршоо нь хүлэмжид хүнсний ногоо тариалан Оюу Толгой ХХК д нийлүүлж байна.
5. Гавилууд Гурван Шаваг ХХК нь гахайн аж ахуй эрхлэхээр ажиллаж байна. .
6. Дуутын Цагаан Уул ХХК нь малчин өрхүүдэд хороо, бууц засах үйлчилгээ үзүүлэх бизнес эхлүүлсэн.



ОРОН НУТГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ | 2018-2023

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ТОГТВОРТОЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАА-Н БИЗНЕСҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ зорилгоор Оюутолгой ХХК-н санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

ЗОРИЛГО:

► Үндсэн үйл ажиллагаа:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчид, Оюу Толгой ХХК, Ханбогд сумын Засаг Даргын Тамгын Газар хоорондын хамтарсан Гурван Талт Зөвлөлөөс хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйг дэмжих чиглэлийн төслүүдэд зөвлөгөө өгөх.

Ханбогд сумын МАА-н салбарыг хөгжүүлэх 10 жилийн төлөвлөгөөний хүрээнд Оюутолгой ХХК-аас хэрэгжүүлж буй төслүүдэд зөвлөгөө өгөх. Ханбогд сумын нийт малчид, анхан шатны хоршоод, дундын хоршоодын хэрэгжүүлж буй төслүүдэд төлөвлөлт, эзэмшил, ашиглалт, үр ашгийг гишүүд малчдад, орон нутагт тэгш хуваарилах чиглэлээр зөвлөгөө өгөх. Үүнд: Мал төхөөрөх үйлдвэр, Мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах худалдааны төв, Малын гаралтай түүхий эдийн худалдааны төв байгуулах төслүүд багтана.

Үр дүн:

2022 онд Ханбогд сумын баг бүрийн оролцоог хангасан хоршоо байгуулах ажилд зөвлөгөө өгсөн. Зөвлөх үйлчилгээний үр дүнд нийт **295 малчин** гишүүдтэй анхан шатны **4 хоршоо** үүсгэн байгуулагдсан.



ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАНБОГД СУМЫН ОРОН НУТГИЙН ХАА-Н БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ

Ханбогд сумын Орон Нутгийн Хөдөө Аж Ахуйн бизнесийг дэмжих стратеги боловсруулахын тулд сумын хэмжээнд мах, сүү, хүнсний ногооны салбарын хөгжлийн боломжуудыг тодорхойлж, энэхүү салбаруудын хөгжлөөс малчдын олох орлогыг нэмэгдүүлэх гарцыг тодорхойлох судалгаа хийж, стратегийн шийдлүүдийг боловсруулсан нь Монгол улсын аль ч сумын хэмжээнд хийж болох санаачилга боллоо.



Сайн туршлага

Энергийн-Ундарга

хоршооны гишүүн **Ш.Ганбат**

өвөлжөөнийхөө хажууд 1 га усалгаатай талбайд царгас, судан өвс, эрдэнэ шиш зэргийг малын тэжээлд зориулж тариалсан бөгөөд 6 тн өвсний ургац авсан. Мөн тарвас, өргөст хэмх, улаан лооль зэрэг таримлуудыг тариалж говийн нөхцөлд газар тариалан, мал аж ахуйг хослон эрхлэх бизнес загварыг



“ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ” SOGЕ ТӨСӨЛ | 2022-2025

► Үндсэн үйл ажиллагаа:

Хөгжлийн шийдэл ТББ нь Европын Холбооны Switch Asia хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын НҮҮРСТӨРӨГЧИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ, НӨӨЦИЙН ХЭМНЭЛТТЭЙ ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ, УЛМААР ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ зорилготойгоор пийплин нийд ОУТББ, Каритас Чех Репаблик ОУТББ, ТОС холбоотой хамтран Улаанбаатар хот, Эрдэнэт, Сэлэнгэ аймгуудад Эдийн Засгийн Ногоон шилжилт төслийг хэрэгжүүлж байна.

Үр дүн:

Төслийн үр дүнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгэээрхлэгчид баримтлах эко шошгын нэгдсэн стандарт боловсруулж, эко шошгожуулалтын онлайн платформыг шинээр бий болгох, улмаар эко шошгожуулах үйл явцыг санхүүгийн дижитал хэрэгслүүдтэй холбох ба одоогоор энэ талын судалгааны ажлуудыг хийгээд байна.



ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөгжлийн Шийдэл ТББ-ийн гүйцэтгэх захирал Б.Гангис Европын Холбооны СВИЧ-Эйшиа хөтөлбөрийн хүрээнд дөрвөн жил хэрэгжих “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл хамтран хэрэгжүүлэхээр “Пилл ин Нийд” ТББ-ын суурин төлөөлөгч Тимоти Женкинстай хамтын ажиллагааны гэрээнд гарын үзэг зурлаа.



“Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн нээлтийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа. 



Эдийн Засгийн Ногоон Шилжилт төслийн Эрдэнэт хот дахь салбарын нээлт боллоо. 

“ИНГЭНИЙ СҮҮ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОРШОО БАЙГУУЛАХ” ХӨТӨЛБӨР | 2022 он

Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн байгууллагын хэрэгжүүлж буй Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр Хөдөлмөр Эрхлэлтийн Шинэчлэлийг Дэмжих Төслийн захиалгаар Хөгжлийн Шийдэл ТББ нь **Өмнөговь аймгийн Ханбогд суманд Ингэний сүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах** анхан шатны хоршоог үүсгэн байгуулж, ингэний сүү үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлтийн бизнесийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаа.

Хөтөлбөрийн хүрээнд хоршооны тухай ойлголт өгөх цогц сургалт, хоршооны сайн засаглал, бизнесийн тогтвортой байдлыг бий болгох зөвлөх үйлчилгээ, хоршоо шинээр үүсгэн байгуулах коучинг үйлчилгээг 20 малчин иргэдэд үзүүлсэн бөгөөд үүний үр дүнд Монголын анхны ингэний сүү бэлтгэн нийлүүлэлтийн хоршоо үүсгэн байгуулагдав. Тус хоршоо нь үндэсний үйлдвэрлэгч TESO компанид ингэний сүү нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, сүүний чанар, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД:

- Малчдын хоршооны талаарх мэдлэг, ур чадвар нэмэгдэх, хоршооны үр ашиг, ингэний сүүний үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх
- Хоршооны гишүүд хоршооны шийдвэр гаргалт, хяналт, засаглал, бизнесийн үйл ажиллагаанд илүү оролцоотой болоход сургалт, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан чадавхжуулах
- Хоршооны засаглалын журмуудыг боловсруулах, хоршооны хамтын бизнес хөгжүүлэлт хийгдсэн байх

20 малчин иргэн



21 АЙМГИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛ, СУУРЬШЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ | 2022 он



ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХАНХ СУМЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ | 2022

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Ханх сумын ерөнхий төлөвлөгөөнд хувийн хэвшлийн хөгжлийн стратегийг боловсруулсан бөгөөд сумын аялал жуулчлалд тулгуурласан жижиг, дунд бизнесийн хөгжлийн зураглал боловсруулав. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн

50 бизнес эрхлэгчид бизнесийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгч ажиллав.

АЗИ ДАХЬ НИЙГЭМ, ЭВ НЭГДЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ - II ҮЕ ШАТ | 2022-2023

ЗОРИЛГО:

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) нь Солонгосын Нийгмийн Аж Ахуйн Нэгжийг Дэмжих Агентлаг (KoSEA)-тай хамтран Солонгосын Хөдөлмөр Эрхлэлт, Хөдөлмөрийн Яам (MOEL)-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр 2019 оноос Ази дахь “Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг бэхжүүлэх нь” төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Төслийн I үе шат **БНХАУ, Индонез, Япон, Малайз, Филиппин, БНСУ улсуудад 2019-2020 онд** хэрэгжсэн бол II үе шат **Монгол, Камбож, Киргиз, Тайланд, Вьетнам улсуудад 2022-2023 онд** хэрэгжиж байна. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага нь Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран Монголын анхны Нийгэм, эв нэгдлийн эдийн засаг (НЭНЭЗ)-ийн нөхцөл байдлын талаарх судалгаа, зураглалын ажлыг хийж байна. Энэхүү судалгааны ажлаар Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг үндэсний хэмжээнд тодорхойлж, Зохистой хөдөлмөр, Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах тэдний хувь нэмрийг олон нийтэд илүү сайн ойлгуулах зорилготой. Мөн цаашлаад судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсын Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг бэхжүүлэх бодлогын зөвлөмж хүргүүлэх болно.

➤ Үндсэн үйл ажиллагаа:

ОУХБ-аас боловсруулсан аргачлалын дагуу Азийн 5 улсын судалгааны баг НЭНЭЗ-ийн байгууллагуудын үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээнд анхдагч мэдээллийн эх үүсвэрээр судлан шинжлэх, цаашлаад кейс судалгааны аргачлалаар НЭНЭЗ-ийн байгууллагуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, тогтвортой хөгжлийн зорилтот оруулж буй хувь нэмрийг гүнзгийрүүлэн судлах ажлуудыг шат дараатайгаар боловсруулан үндэсний хэмжээний зураглал гаргах юм. НЭНЭЗ-д хоршоо, сан, хамтын нийгэмлэг, нийгмийн аж ахуйн нэгж, өөртөө туслах бүлгүүд болон бусад ижил төстэй байгууллагууд багтдаг.

➤ ОУХБ-аас Ази дахь “Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг бэхжүүлэх төсөл”-ийн анхдугаар хуралдааныг **Монгол, Камбож, Тайланд** улсуудад зохион байгууллаа.

ОУХБ-ын гурван талт хорооны гишүүд болон нийгэм, эв нэгдлийн эдийн засгийн түнш байгууллагуудад Ази дахь **“Нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг бэхжүүлэх”** төслийг танилцуулах зорилгоор төслийн танилцуулга уулзалтыг ОУХБ, Хөгжлийн Шийдэл ТББ хамтран үндэсний зөвлөх хорооны анхдугаар хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг уулзалтад үндэсний зөвлөл хорооны гишүүд болон ОУХБ-ын төлөөллүүд цахимаар болон биечлэн оролцож санал, зөвлөмжөө нээлттэй хуваалцлаа.



Төсөл нь дараах үр дүнд хүрэх зорилт тавин ажиллаж байна. Үүнд:

- **1-р үр дүн.** Азийн 6 оронд НЭНЭЗ-ийн талаарх ойлголт сайжирсан
- **2-р үр дүн.** НЭНЭЗ-ийг бодлого/хөтөлбөрүүдэд тусгах оролцогч талуудын чадавх нэмэгдсэн

ЗАЛУУЧУУДЫН БИЗНЕСИЙН САНААЧИЛГА-ҮВМ



| 2013 оноос одоог хүртэл

Их Британи, Умард Ирландын Вант Улсад төвтэй Youth Business International ОУБ-ын гишүүнээр 2013 оноос хойш ажиллаж буй Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол Улсад залуучуудын ажлын байр, бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор Youth Business Mongolia хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд өөртөө болон бусдад ажлын байр бий болгож, энтрепренер болох хүсэлтэй **18-35 насны залууст** зориулсан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

➤ **Үндсэн үйл ажиллагаа:**

- Энтрепренершипыг хөгжүүлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх
- Шинэ инновацлаг санаа бүхий энтрепренерүүдийг бэлтгэх
- Орон нутагт гарааны бизнесээ эхэлж байгаа залуучуудад дэмжлэг үзүүлэх, тэднийг чадавхжуулах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Залуусын хүсэл мөрөөдөл, зорилгыг нийгэмд таниулах
- Сайн дурын бизнес менторуудыг бий болгох
- Нийгмийн болон ногоон энтрепренершипыг дэмжих
- Зах зээл болон санхүүжилттэй холбох үйлчилгээ

2022 онд

1,704 энтрепренер залууст сургалт, зөвлөгөө өгч,

234

залуусыг бизнесийн санхүүжилт авахад нь тусалж,

201

залуусыг бизнесийн ментортой болгов.

НОГООН БОЛОН НИЙГМИЙН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ КОУЧИНГ ХӨТӨЛБӨР

ЭНТРЕПРЕНЕР ЗАЛУУЧУУДЫН НОГООН БОЛОН НИЙГМИЙН БИЗНЕСИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, БИЗНЕС ЗАГВАРАА ШИНЭЧЛЭН ХӨРВҮҮЛЭХЭД ДЭМЖИХ ЗОРИЛГООР КОУЧИНГ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭВ.


Тус хөтөлбөрийг **Армен, Мозамбик, Барбадос, Кени улсын коуч багш** нартай хамтран боловсруулж, **Улаанбаатар, Орхон, Дархан, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Хэнтий, Ховд, Баянхонгор, Завхан** аймгийн 26 бизнес эрхлэгч залуучууд энэхүү 4 сарын хугацаатай коучинг хөтөлбөрт хамрагдсанаар байгальд ээлтэй бизнес эрхлэх эрхэм

зорилгоо тодорхойлон, тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд бизнес загвараа шинэчлэн, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах бизнес эрхлэхийн давуу талыг ойлгож мэдэв. Бид энэхүү хөтөлбөрөө 2023 онд үргэлжлүүлэн 80 энтрепренер залуусыг хамруулахаар төлөвлөж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МЕНТОРИНГ ХӨТӨЛБӨР



ҮВМ хөтөлбөрийн хүрээнд бизнесийн мэдлэг, туршлагатай менторуудыг бэлтгэх, туршлагатай менторуудыг шинэ залуу бизнес менти нартай холбох үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд ментор болон менти нарт зориулсан сургалт, менторинг холболтын үйл ажиллагааг тогтмол явуулж байна.

2022 онд

800 гаруй менторуудад сургалт,

200 менторинг холболт хийгээд байна.

Амжилт:



ҮВМ ОУБ нь жил бүр **‘дэлхийн шилдэг ментор’, ‘дэлхийн шилдэг ЭНТРЕПРЕНЕР ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧ’**-ийг шалгаруулдаг бөгөөд энэ жилийн шалгаруулалтад Монгол Улсаас ҮВМ хөтөлбөрийн Ментор **Р. Болор** нь нэр дэвшиж **“ТӨВ АЗИ, ЗҮҮН ЕВРОПЫН БҮСИЙН ШИЛДЭГ МЕНТОР”** боллоо.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ИРГЭДЭД БИЗНЕСИЙН БОЛОН ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР ОЛГОХ ЧАТБОТ СИСТЕМ

Бизнесийн болон хувь хүний ур чадвар олгох мэдлэгийг тусгай хэрэгцээт иргэдэд олгох, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес, менежмент, санхүү гэсэн үндсэн **3 агуулгын 20 сэдвээр** богино сургалтууд бэлдэн аудио, текст, дохионы хэлбэрээр чатбот дээр байршуулаад байна. ҮВМ олон нийтийн сүлжээнд (<https://www.facebook.com/YouthBusinessMongolia>) нэвтрэн шаардлагатай мэдээллүүдийг үнэ төлбөргүй хүлээн авах боломжтой. Түүнчлэн **Индонез, Солонгос** болон **Вьетнамын** бизнесийг дэмжих төвүүд туршлага судлан энэхүү үйлчилгээг өөрсдийн оронд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

- 1 БИЗНЕС
- 2 МЕНЕЖМЕНТ
- 3 САНХҮҮ

Fb: YouthBusiness Mongolia



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

| 2010 оноос одоог хүртэл

ЗОРИЛГО:

2010 оноос Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны санхүүжилттэй Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ажлын байр бий болгох, Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, Гарааны бизнесийг дэмжих, Аж ахуй эрхлэлтийг дэмжих зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр Халамжийн Хэлтсүүдтэй хамтран ажиллаж байна.

Үр дүн:

2022 онд **Улаанбаатар хот, Баянхонгор, Дархан, Дорноговь, Дундговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Өмнөговь** аймгийн хөдөлмөр халамжийн байгууллагатай хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт **1577** иргэн, аж ахуй нэгжийг бизнес эрхлэлтийн болон гарааны бизнесийн сургалтад хамруулж, **80** бизнесийг **658 сая** төгрөгийн санхүүжилттэй холбож өгсөн байна.

Ундсэн үйл

ажиллагаа:

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн иргэд болон бизнес эрхлэх, бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжүүдэд бизнес хөгжлийг дэмжих сургалт, менторинг, зээл санхүүжилтэд холбох зэрэг үйлчилгээг үзүүлдэг.



ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН “ШИЛДЭГ ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ШАЛГАРУУЛАХ” ҮЙЛ АЖИЛЛАГАА



Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газрын захиалгаар шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санаачилга гаргаж буй залуучуудын багийг шалгаруулж, санхүүжилт олгох зорилготой “ШИЛДЭГ ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ШАЛГАРУУЛАХ” үйл ажиллагааг **Стартап Монгол ТББ, Стартап Маркетинг Спэйстэй** нэгдсэн байдлаар хамтран зохион байгуулсан.

Тус үйл ажиллагааны үеэр Хөгжлийн Шийдэл ТББ нь **Баянзүрх, Багануур, Хан-Уул дүүргийн** нийт

91 залуусыг бизнес хөгжлийн сургалт, хурдасгуур хөтөлбөр, ментор зөвлөх үйлчилгээгээр дамжуулан чадавхжуулсан.



ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-Н ЗҮГЭЭС 2022 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУДДАА
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

DEVELOPMENT SOLUTIONS NGO WOULD LIKE TO
EXPRESS ITS GRATITUDE TO THE ORGANIZATIONS
THAT COLLABORATED IN 2022.

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН ТҮНШЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ	 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ	 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР	 USAID FROM THE AMERICAN PEOPLE	 Европын Холбоо санхүүжүүлэв
 ybi Youth Business International	 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ	 Food and Agriculture Organization of the United Nations		 International Labour Organization
 AustCham Mongolia	 БОГД БАНК ИГЭЭ ТҮЭЭНЭ	 ТӨРИЙН БАНК	 TDB ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	 ГОЛОМТ БАНК
 MMCi Mongolian Management Consultants' Institute	 ХААН БАНК	 ХАСБАНК	 TransBank	 DMUV Дотоодын Мөнгөний Урьдчилсан Банк
 MBA	 PMI Project Management Institute, Mongolia	 STARTUP MONGOLIA	 STARTUP MARKETING SPACE	 МБИҮНХ

OUR PARTNER ORGANIZATIONS

	 НИЙСЛЭЛИЙН ЖДҮҮДТ	 ХӨДӨЛМӨР, ХАЛХАМЖИЙН ҮЙЛЧИГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР	 ЗЭЭМИЙН БАТААН ДААЛТЫН САН	
 WORLD BANK	 switchasia		 Caritas Czech Republic	 Оюу Толгой
 КАПИТРОН БАНК	 АРД КРЕДИТ ББСБ	 GSB CAPITAL	 InvesCore	 ТРАНСКАПИТАЛ
 МОНГОЛЫН БИЧИЛ УУРСАЙН НОГОСН ДЭРӨНГ ХОЛБОО	 THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA	 TOC МОНГОЛЫН ТУУ ХӨДӨӨ ЭРХЛЭЛТИЙН ХӨНӨӨ	 МУХАҮТ	 ГАЗАР ТАРИАЛАН ХОЛБОО
				